



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/304

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2025 оны 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.4.2, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.5.3 дахь хэсгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын ивээл дор Баруун бүсийн өсвөрийн аварга шалгаруулах шатрын тэмцээнийг зохион байгуулах зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах 8,175,000 (найман сая нэг зуун далан таван мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга(Ш.Эрдэнэбат)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар) Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

